



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
БҮСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2023 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/53

Арвайхээр

Г

Журам батлах тухай

Г


Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.7 дах заалт, Монгол Улсын “Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлэх удирдамж” MNS ISO/TS 9002:2020 стандарт, “Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагаа” MNS 5095:2017 стандарт, “Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага” MNS 6392:2013 стандарт, “Эмчилгээ, оношилгооны түгээмэл үйлдлүүд” MNS 4621:2008 стандарт, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/814 дугаартай “Журам шинэчилэн батлах тухай” тушаал, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 дугаартай “Эрүүл мэндийн салбарын статистик мэдээ, мэдээллийн журам, бүртгэлийн маягтыг шинэчлэн батлах тухай” тушаал, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/406 дугаартай “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм” тушаал, Эрүүл мэндийн сайдын 2015 оны 483 дугаартай “Өдрийн эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх тухай” тушаал, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/537 дугаартай “Заавар батлах тухай” тушаал, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/538 дугаартай “Олон эмэнд тэсвэржсэн зарим бичил биетний тандалт, халдвараас сэргийлэх, хянах заавар батлах тухай” тушаал, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/539 дугаартай “Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдварыг тандах заавар батлах тухай” тушаал, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 505 дугаартай “Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах заавар батлах тухай” тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Бүсийн оношилгооны эмчилгээний төвөөс үйлчлүүлэгчид мэс заслын болон эмийн өдрийн эмчилгээний тусламж үйлчилгээг үзүүлэх “Эмчлүүлэгчид өдрийн эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх журам”-ыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2.“Эмчлүүлэгчид өдрийн эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх журам”-ыг 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлж, тусламж үйлчилгээг чанартай, тэгш хүртээмжтэй, аюулгүй байдлыг хангаж, цаг алдахгүй хүргэж байхаар зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг эмнэлзүй эрхэлсэн дэд захирал (Д.Болормаа), Сувилахуйн албаны дарга (Б.Тунсагбямба), зөвлөх эмч нар, эм зүйн албаны дарга (Ц.Мөнгөнтуяа), тасгийн эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, тусламж үйлчилгээг чанартай, тэгш хүртээмжтэй, аюулгүй байдлыг хангаж, цаг алдахгүй хүргэж ажиллахыг Гүйцэтгэлийн удирдлага дотоод хяналтын албаны дарга (Д.Аззаяа), Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын албаны дарга Ц.Лувсандамдин нарт тус тус даалгасугай.

ЗАХИРАЛ

 Г.ДАШЖАНЦАН

D.doc.tushaal-2023 on